



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 1136

Чойбалсан

Г

Дэмжлэг үзүүлэх тухай

Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.1, 2.1.4, 4.3, 5.2, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 06 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилт хүндэрч, мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр "Цагаан зуд"-ын ангилалд шилжсэн Матад, Халхгол сумдын аюулгүйн нөөцөд өвс тэжээлийг нэмж бүрдүүлэхэд 31,200,000 (гучин нэгэн сая хоёр зуу мянган) төгрөгийг дэмжлэг үзүүлсүгэй.

2. Өвс, тэжээл нэмж бүрдүүлэхэд шаардагдах санхүүжилтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Зардлын төгрөгийг 31,200,000 (гучин нэгэн сая хоёр зуу мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (П.Бат-Өлзий)-д зөвшөөрсүгэй.

4. Батлагдсан зардлыг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнаж ажиллахыг Матад сумын Засаг дарга (Д.Баттулга), Халхгол сумын Засаг дарга (Х.Хүрэл-Эрдэнэ) нарт тус тус үүрэг болгосугай.


5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ш.Ёл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН

Аймгийн Засаг даргын 2014 оны
2 дугаар сарын 28-ны өдрийн
113 захирамжийн хавсралт



ӨВС, ТЭЖЭЭЛ НЭМЖ БҮРДҮҮЛЭХЭД
ШААРДАГДАХ САНХҮҮЖИЛТЫН ТООЦОО

№	Сумын нэр	Санхүүжүүлэх дүн (төгрөг)
1	Матад	11,550,000
2	Халхгол	19,650,000
	Дүн	31,200,000

---oOo---